



Annex 6

Rules and Regulations

*Rules of National Council for Identifying Intangible Cultural Heritage and its Bearers
Regulations on identifying and registering intangible cultural heritage and its bearers*

Minister ordinance No. 414

Minister of Education, Culture and Science of Mongolia, October 02 2009

Rules of National Council for Identifying Intangible Cultural Heritage and its Bearers

I. Overview

1. National Council for Determining intangible cultural heritage bearers (hereafter 'National Council') shall be an advisory body to provide advice and consultations to Ministry of Education, Culture and Science and its Minister, in regards to issues regulating relations associated with determining, registering, documenting, safeguarding, maintaining, transmitting, developing and promoting State support to genuine forms of intangible cultural heritage (hereafter as 'Intangible cultural heritage') and their bearers in Mongolia, in compliance with concepts of UNESCO 'Convention for the Safeguarding of the Intangible Cultural Heritage' adopted in 2003.
2. National Council shall comply the Constitution of Mongolia, State Policy on Culture, Law on Culture, Law on the Protection of Cultural Heritage, other relevant laws and relations, international and bilateral treaties and agreements, and this Rule within its functions and activities.
3. National Council membership shall mainly consist of representatives from professional non-governmental organizations, scholars and researchers operating within culture theories, history, management and marketing affairs, as well as within areas of intangible cultural heritage forms, such as oral traditions expressed in the Mongolian language, traditional performing arts, social practices, rituals and festive events, knowledge and practices concerning nature and the universe, traditional craftsmanship and techniques. Members shall be selected and appointed every five years.

II. Organizational structure of National Council

1. National Council shall be an advisory body comprised of the Chairperson, Deputy Chairperson, secretary and 20-22 members.
2. Six expertise teams shall operate under National Council as below:
 - Expert team on Culture theory, history, management and marketing affairs;
 - Expert team on Oral traditions expressed in the Mongolian language;

- Expert team on Performing arts;
- Expert team on Social practices, rituals and festive events;
- Expert team on Knowledge and practices concerning nature and the universe;
- Expert team on Traditional craftsmanship and techniques.

Each expert team shall consist of 4-7 members and the Team Leader shall be elected through open voting during a National Council meeting. The National Council Chairperson, Deputy Chairperson, Secretary and members may hold membership in no more than three expert teams each.

3. A local Sub-Council for Identifying Intangible Cultural Heritage Bearers (hereafter Sub-Council) shall be set up by the order of the provincial and capital Governor and operating in Ulaanbaatar city and all provinces. The membership components and procedural rule of each Sub-Council shall be approved by Chairperson of the National Council.
4. Main activities of National Council shall be National Council meetings; its regular meeting shall be held within the first half of June annually, and emergency meetings may be called for or convened by Chairperson's competence, or by Deputy chairperson based on Chairperson's approval in case of his absence.
5. The secretary of National Council shall deliver the meeting agenda, related materials and announcement stating meeting premise location, date and time, to all members seven days prior to the meeting date.
6. Meeting minutes shall be produced after each meeting and the Chairperson, Vice Chairperson and the Secretary shall sign the approved minutes.

III. Functions of the National Council

1. National Council shall discuss and revise the issues in regards to the identification and registration of the intangible cultural heritage and its bearers submitted by the Centre for Cultural Heritage and submit the discussion outcome, including the draft decision, introduction, comments and other materials to the Minister of Education, Culture and Science.
2. National Council shall submit the annual operational report to the Ministry of Education, Culture and Science, Culture and Arts Committee, Mongolian National Commission for UNESCO and other central and local relevant organizations within January annually.
3. National Council shall deal with the issues related to the cancellation of the heritage bearer's certificate, transmission of the certificate to the heritage learner, and cancellation of the right of heritage bearer and submit the relevant comments to the Minister of Education, Culture and Science.

IV. Rights of National Council members

1. National Council members shall exercise rights to participate its meeting with voting rights, express own requests and viewpoints freely, and submit proposals over issues, concerning intangible cultural heritage and its bearers, to the National Council.
2. National Council members – within their expert team membership status – shall have rights to monitor compliance of contract agreements established

between heritage bearers and Culture and Arts Committee, review performance reports and inquire necessary information from them, if necessary.

3. National Council members shall have rights to make queries from Culture and Arts Committee, Cultural Heritage Center, and relevant local institutions, in order verify information related to revoking, terminating and transferring heritage bearers' certificates.
4. National Council Chairperson, Deputy chairperson, secretary and members shall be issued member's ID card signed by Minister of Education, Culture and Science so that they shall present their Member's ID card to encounter with relevant agencies and individuals within their membership status.
5. National Council members shall be able to submit and reflect proposals on work conditions, excessive duties and tasks, business trip costs, remuneration and incentives, as well as on strengthening work performance efficiencies or other comments to be reflected to the minutes of National Council meetings.
6. The chairperson, deputy chairperson, secretary and members of the National Council may submit personal requests to resign from their positions based on own wills, and to terminate and change membership status to the Minister of Education, Culture and Science in writing.

V. Obligations and responsibilities of National Council members

1. National Council members shall be responsible for participating its routine meetings regularly and actively, reviewing all applications submitted from prospective heritage bearers, and viewing prospective heritage bearers' talents and skills in person.
2. National Council members shall be responsible for following duties, such as develop relevant policy proposals over intangible cultural heritage related issues; create adequate legal frameworks; conduct research; develop database registration; communicate with and provide support to heritage bearers; make efforts in transmitting intangible cultural heritage to young generations; organize public awareness activities and introduce heritage to general public; organize contest events; participate in activities aimed to expand heritage bearers' fame and reputations among general public; particularly, assure urgent protection of intangible cultural heritage types in danger of disappearing; develop intangible cultural heritage elements in line with modern science and technology achievements and ongoing development needs; register certain heritage types in UNESCO List of intangible cultural heritage; and make initiatives in promoting Mongolia's fame and reputations as high as possible.

Regulations on identifying and registering intangible cultural heritage and its bearers

I. Objective

The purpose of this Procedure is to regulate relations associated with the State support on identifying, registering, safeguarding, transmitting and developing intangible cultural heritage and its bearers in Mongolia in compliance with concepts and principles stipulated in the Constitution of Mongolia, the State policy on culture, Law on Culture, Law on Preserving cultural heritage, other Mongolian legislations and international treaties and agreements endorsed and ratified by Mongolia.

II. Interpretations

1. Intangible cultural heritage refers to the following aspects and features based on concepts stated in 2003 UNESCO Convention for the Safeguarding of the Intangible Cultural Heritage, including:
 - Intangible cultural heritage expressed in Mongolian language:
Fairy tales, epics, well-wishing songs, praise songs, idioms, poems about traditional customs, well-wishing expressions, tongue twisters and other features of oral traditions and oral literature genres
 - Traditional performing arts:
Folklore songs and dances, including long and short songs, huumei(throat-singing), whistle songs, morin khuur(horse headed fiddle), flute, aman khuur (mouth harp), bii biyelgee(dance of the body) and tsam(mask dance)
 - Social customs, ceremonies and festivities:
Traditional customs, ceremonial events, celebrations and festivities
 - Knowledge and customs associated with nature and wild life:
Multiple features knowledge and skills associated with observing the Earth, watercourse, sky and weather patterns, and approaching the nature and the Earth, as well as traditional heritage elements related to sacred places, nature conservation customs and customary restrictions
 - Traditional craftsmanship heritage:
Traditional craftsmanship techniques and skills of Mongolian metal-smith, carpentry, wooden artifacts, sewing, embroidery, felt quilting, leather crafting, and livestock production techniques
2. Intangible cultural heritage bearer (hereafter as 'Heritage bearer') refers to individuals certified with a Certificate issued by Minister for Education, Culture and Science based on evaluation by and approval from the National council for identifying intangible cultural heritage and its bearers; and
3. Intangible cultural heritage learner (hereafter a 'Heritage learner') refers to individuals who are formally registered and currently being taught relevant knowledge by Heritage bearers, and so have not received a certificate of 'Intangible cultural heritage bearer' yet.

III. Identifying and registering the prototype of the intangible cultural heritage and its bearers

1. National Council for Identifying and Registering Intangible Cultural Heritage (hereinafter referred to as National Council) is the official body in charge of the identification of the intangible cultural heritage and its bearers of Mongolia. The establishment and its procedural rule of the National Council shall be approved by Decree of Minister of Education, Culture and Science.
2. Centre for Cultural Heritage, affiliated to the Ministry of Education, Culture and Science shall elaborate the draft of 'The List of Local Intangible Cultural Heritage and its Bearers' in cooperation with the relevant governmental organizations as well as the professional NGOs
3. The Center for Cultural Heritage shall issue and distribute annual public announcement together with the comprehensive and detailed information on the applications for the prospective heritage bearers through media in order to identify and select prospective heritage bearers on November annually.
4. Applicants (both individuals and groups) for official registration as 'Heritage bearer' shall submit their application to the Center for Cultural Heritage in the first quarter annually. Application shall be open to public.
5. Centre for Cultural Heritage shall carefully review the applications and conduct in-situ inspection if necessary.
6. Based on the applications from the prospective heritage bearers and the draft of 'The List of Local Intangible Cultural Heritage and its Bearers', Centre for Cultural Heritage shall draft the 'List of the Intangible Cultural Heritage in Mongolia' and the 'List of the Intangible Cultural Heritage Bearers in Mongolia' and submit to the National Council together with the relevant documents, comments and materials within the second quarter annually. The ICH and bearer that are not included in the 'The List of Local Intangible Cultural Heritage and its bearers' shall not be included into 'List of the Intangible Cultural Heritage in Mongolia' and the 'List of the Intangible Cultural Heritage Bearers in Mongolia'.
7. National Council shall review the drafts of aforementioned lists and submit the discussion outcome on the lists along with the comments and conclusions to the Minister of Culture, Education and Science before August 10 annually.
8. 'List of the Intangible Cultural Heritage in Mongolia' and the 'List of the Intangible Cultural Heritage Bearers in Mongolia' shall come into effect through the approval of the Minister of Culture, Education and Science.
9. Approvals of intangible cultural heritage shall be informed to the relevant organizations and announced through the mass media. The certificate for the heritage bearers shall be handed to approved heritage bearers on the 'Culture and Arts Practitioners' Day of Mongolia' (Second Sunday of September every year)
10. The Center of Intangible Cultural Heritage will keep documentation materials (such as ordinary and digital photographs, VCD, DVD, CD, audio tape, illustrations and other physical items) enclosed to application for registration as a Heritage bearer, as well as recorded tapes, photographs and other documentation materials produced during selection processes of the National Council.

IV. Rights of cultural heritage bearers

1. A heritage bearer (individuals and groups) shall hold full rights to demonstrate, advertise, perform intangible heritage and related skills with his/her ownership, exhibit and display at museums, establish non-governmental organizations, conduct trainings within relevant legal frameworks and make request on transferring his/her Heritage bearer's ownership rights.
2. A heritage bearer shall submit a request for running activities associated with heritage owned, to the National Council, MECS and the responsible Minister through the Culture and Arts Committee.
3. A heritage bearer shall exercise rights to express own opinions, cooperate and file complaints over materials associated with his/her certified intangible cultural heritage that were broadcast on television and radio, printed on newspapers and magazines, displayed through concerts and exhibitions, published in advertisements and research articles, or copied and distributed publicly.
4. A heritage bearer shall have rights to select heritage learners and offer them own policy, approaches and activities associated with transmitting own outstanding skills and talents.

V. Responsibilities of cultural heritage bearers

1. A heritage bearer shall make agreement with the Centre for Cultural Heritage in valid for 2-3 years. The regulation of agreement shall be approved by the chief of the Culture and Arts Committee.
2. A heritage bearer shall be responsible for transmitting own outstanding talents and skills to the next generation, particularly traditional and ethnic intangible cultural heritage endangered to extinct.
3. A heritage bearer shall be active and enterprising for the activities toward the safeguarding of the ICH and take part in the various cultural events in local, national and international levels.
4. A heritage bearer shall consider and seek for ways to develop own intangible cultural heritage and outstanding skills in line with achievements of modern technology and science and with existing needs and demands.
5. A heritage bearer shall ensure the heritage learner's preparation prior submitting application for registration in the list of intangible cultural heritage bearers
6. A heritage bearer shall submit annual report to the Center for Cultural Heritage within November.

VI. Rights and responsibilities of Heritage learners

1. A heritage learner shall be entitled to choose heritage bearers and present requests on learning heritage bearer's outstanding talents and skills.
2. A heritage learner shall hold rights to express opinions, request and complaints to the heritage bearer and Centre for Cultural Heritage in regards to training policy, approaches and activities, as well as rights to refuse from trainings.

3. A heritage learner shall demonstrate learned talents and skills in person during the performance reporting to the National Council and the Centre for Cultural Heritage in order to get relevant evaluation approval.
4. A heritage learner shall learn heritage bearer's outstanding talents and skills chosen, and prepare for registration in the List of intangible heritage bearers.
5. Any change and amendment in the application for the selection of the bearer of intangible cultural heritage shall be informed to the Centre for Cultural Heritage



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2009 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 414

Улаанбаатар хот

Үндэсний зөвлөл байгуулах,
дүрэм, журам батлах тухай

Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага (ЮНЕСКО)-ын Ерөнхий бага хурлын 32 дугаар чуулганаар 2003 оны 10 дугаар сарын 17-ны өдөр баталсан "Соёлын биет бус өвийг хамгаалах тухай" Конвенцийн 12, 17 дугаар зүйл, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд бөгөөд ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын даргын баталсан "Биет бус соёлын өвийг хамгаалах тухай" ЮНЕСКО-гийн конвенцийг хэрэгжүүлэх 2009 оны төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Соёлын биет бус өв, түүнийг тээгчийг тогтоох үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн"-ийг нэгдүгээр, "Соёлын биет бус өв, түүнийг тээгчийг тогтоох үндэсний зөвлөлийн дүрэм"-ийг хоёрдугаар, "Соёлын биет бус өв, түүнийг тээгчийг тогтоох, бүртгэх журам"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2010 оноос эхлэн жил бүр батлан ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд бөгөөд Биет бус соёлын өв, түүнийг тээгчийг тогтоох үндэсний зөвлөлийн дарга Ч.Куландад даалгасугай.

3. Энэ тушаалыг ЮНЕСКО-д хүргүүлэх, хэвлүүлэн сурталчлах, шаардлагатай үед нэмэлт, өөрчлөлт оруулан шинэчлэх арга хэмжээ авч ажиллахыг Соёл, урлагийн бодлогын газар /Г.Эрдэнэбат/, Соёлын өвийн төв /Г.Энхбат/, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс /Н.Уртнасан/-т тус тус даалгасугай.



Е.ОТГОНБАЯР

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2009
оны дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**Соёлын биет бус өв, түүнийг тээгчийг тогтоох
үндэсний зөвлөлийн дүрэм**

I. Ерөнхийзүйл

1. Соёлын биет бус өв, түүнийг тээгчийг тогтоох үндэсний зөвлөл (цаашид Үндэсний зөвлөл гэх) нь ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны конвенцийн үзэл санааг үндэслэн Монгол Улс дахь соёлын биет бус өвийн жинхэнэ эх хэв шинж (цаашид соёлын биет бус өв гэх), түүнийг тээгчийг тогтоох, бүртгэх, баримтжуулах, хадгалж хамгаалах, өвлүүлэн хөгжүүлэх, тэрчлэн төрөөс дэмжих харилцааг зохицуулах асуудлаар соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, сайдад зөвлөх эрхтэй орон тооны бус байгууллага болно.

2. Үндэсний зөвлөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрөөс баримтлах соёлын бодлого, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, бусад хууль тогтоомж, олон улстай байгуулсан гэрээ, хэлэлцээр болон энэхүү журмыг үйл ажиллагаандаа удирдлага болгоно.

3. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд соёлын онол, түүх, соёлын менежмент, маркетинг болон монгол хэлээр илэрхийлэгдэх соёлын биет бус өв, язгуур урлаг, нийгмийн уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам, байгалийн болон сав, шимийн ертөнцийн тухай мэдлэг, заншил, ардын гар урлал, уламжлалт арга ухааны өвийн чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачдын төлөөллийг оруулж, Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр 5 жилийн хугацаагаар томилон ажиллуулна.

II. Үндэсний зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

1. Үндэсний зөвлөл нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, 17-23 гишүүнтэй байна.

2. Үндэсний зөвлөлийн гишүүд нь дараах чиглэлээр шинжээчийн 6 багт ажиллана. Үүнд:

- 1/ Соёлын онол, түүх, соёлын менежмент, маркетингийн;
- 2/ Монгол хэлээр илэрхийлэгдэх соёлын биет бус өвийн;
- 3/ Язгуур урлагийн;
- 4/ Уламжлалт зан үйл, ёслол, баяр наадмын;
- 5/ Байгалийн болон сав шимийн ертөнцийн талаархи мэдлэг, заншил, эрдэм ухааны уламжлалын;
- 6/ Ардын гар урлал, уламжлалт арга ухаан, технологийн;

Шинжээчийн баг тус бүр 4-7 хүний бүрэлдэхүүнтэй ажиллах бөгөөд багийн ахлагчийг Үндэсний зөвлөлийн хуралдаанаас илээр сонгоно. Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүн нь 3-аас илүүгүй шинжээчийн багт орж ажиллаж болно. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд Үндэсний зөвлөлийн шинжээчийн ямар багийн төлөөлөл мөн болохыг нь гэрчилсэн үнэмлэх олгоно.

3. Аймаг, нийслэлд Соёлын биет бус өв, түүнийг тээгчийг тогтоох салбар зөвлөлийг тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулж ажиллана. Салбар зөвлөлийн үлгэрчилсэн дүрмийг Үндэсний зөвлөлийн дарга батална.

4. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь түүний хурал байна. Үндэсний зөвлөлийн ээлжит хурлыг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор дарга, түүний эзгүйд дэд дарга зарлан хуралдуулна. Үндэсний зөвлөлийн даргын зөвшөөрснөөр ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно. Зөвлөлийн гишүүдийн ирц 70-аас доошгүй хувь бүрдсэн тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно. Хуралд оролцсон гишүүдийн 80-аас дээш хувийн саналаар хурлын шийдвэр, дүгнэлт хүчинтэй болно.

5. Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хэлэлцэх асуудалтай холбоотой бичиг баримтыг бэлтгэн, хурал эхлэхээс 7 хоногийн өмнө Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд тараана.

6. Үндэсний зөвлөлийн хурлаас хуралдааны тэмдэглэл гарах бөгөөд тэмдэглэлд хуралдааны дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

III. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа

1. Үндэсний зөвлөл нь Соёлын өвийн төвөөс өргөн мэдүүлсэн соёлын биет бус өв, түүнийг тээгчийг тогтоох, бүртгэх асуудлыг хурлаараа хянан хэлэлцээд жил бүрийн 8 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө энэ тухай шийдвэрийн төсөл, танилцуулга, санал, дүгнэлтээ соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, сайдад өргөн мэдүүлнэ.

2. Үндэсний зөвлөл жилийн үйл ажиллагааны тайлан, санал, дүгнэлтээ соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Соёл, урлагийн хороо, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс, Соёлын өвийн төв болон төв, орон нутгийн холбогдох байгууллагад жил бүрийн 1 дүгээр сард хүргүүлж байна.

3. Өв тээгчийн эрхийг цуцлах, өвлөн суралцагчид шилжүүлэх, батламжийг хүчингүй болгох тухай асуудлыг судлан үзэж, санал дүгнэлтээ соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, сайдад өргөн мэдүүлнэ.

IV. Үндэсний зөвлөлийн гишүүний эрх

1. Үндэсний зөвлөлийн хуралд таслах эрхтэй оролцож, өөрийн санал хүсэлт, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэн, соёлын биет бус өв болон өв тээгчтэй холбоотой асуудлыг Үндэсний зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхээр санал оруулна.

2. Гишүүн нь шинжээчийн үүргийг давхар гүйцэтгэх бөгөөд шаардлагатай үед тухайн өв, өв тээгчтэй биечлэн танилцаж, санал, дүгнэлтээ Үндэсний зөвлөлд оруулна.

3. Өв тээгчээс Соёлын өвийн төвтэй байгуулсан гэрээний биелэлтэнд хяналт тавин, үйл ажиллагааны тайлантай нь танилцаж, зөвлөмж өгнө.

4. Өв тээгчийг шагнаж урамшуулах, түүнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, батламжийг нь хүчингүй болгох, эрхийг цуцлах, шилжүүлэх асуудлаар байгууллага, хүмүүсээс гаргасан саналыг нягтлан шалгаж, Соёл, урлагийн хороо, Соёлын өвийн төв, орон нутгийн холбогдох байгууллагаас мэдээлэл авна.

5. Ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх, зөвлөлийн бүрэлдэхүүнд дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох талаар санал, хүсэлт гаргана.

6. Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүн нь өөрийн хүсэлтээр сонгуульт үүргээсээ татгалзаж болно.

Ү. Үндэсний зөвлөлийн гишүүний үүрэг:

1. Үндэсний зөвлөлийн хуралдаанд оролцож, соёлын биет бус өв болон түүнийг тээгчийг тогтоох, хүсэлт гаргагчдын өргөдөл, материалыг судлан үзэх, тэдний авъяас чадвартай биечлэн танилцана.

2. Соёлын биет бус өвийн талаар оновчтой бодлого боловсруулах, эрх зүйн орчин бүрдүүлэх, судалгаа хийх, бүртгэл гаргах, өв тээгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, өвийг өвлүүлэх, сурталчилах, олны хүртээл болгох, өв тээгчдийг урамшуулан алдаршуулах, ялангуяа мартагдаж, устаж үгүй болоход хүрээд байгаа өвийг хадгалж хамгаалах, орчин үеийн шинжлэх ухаан, технологийн ололт, өнөөгийн цаг үеийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, тэдгээрийг ЮНЕСКО-гийн соёлын өвд бүртгүүлэх талаар идэвхи санаачлагатай ажиллана.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2009 оны дугаар тушаалын гуравдугаар хавсралт

Соёлын биет бус өв, түүнийг тээгчийг тогтоох, бүртгэх журам

I. Зорилго

Монгол Улсын Үндсэн хууль, Төрөөс баримтлах соёлын бодлого, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомж, олон улстай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн үзэл санаанд нийцүүлэн Монгол Улс дахь соёлын биет бус өвийн язгуур хэв шинж (цаашид Соёлын биет бус өв гэх), түүний тээгчийг тогтоох, бүртгэх, баримтжуулах, хадгалж хамгаалах, өвлүүлэн хөгжүүлэх, өвлөн тээгчдэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх, урамшуулах үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

II. Нэр томъёо

а. Соёлын биет бус өв гэдэгт ЮНЕСКО-ийн соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны конвенцийн утга санааг үндэслэн дараах чиглэл, төрөл, зүйлийг ойлгоно. Үүнд:

1. Монгол хэлээр илэрхийлэгдэх соёлын биет бус өв

Эх хэл, түүгээр илэрхийлдэг аман билиг, үлгэр, домог, тууль, ерөөл, магтаал, зүйр цэцэн үг, ардын зан үйлийн шүлэг, цацал мялаалгын үгс, түргэн хэллэг, ардын аман болон утга зохиолын бусад бүтээл гэх мэт;

2. Язгуур урлаг

Ардын уртын болон богинын дуу, хөөмий, исгэрээ, морин хуур, цуур, аман хуур зэрэг дуу хөгжмийн уламжлалт урлаг, бий, биелгээ, цам зэрэг уламжлалт бүжгийн урлаг гэх мэт;

3. Ардын уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам

Уламжлалт зан үйл, арга барил, баяр ёслол, баяр наадам гэх мэт;

4. Байгалийн болон сав шимийн ертөнцийн талаархи мэдлэг, заншил, эрдэм ухааны уламжлал

Газар, ус, тэнгэрийн байдал, цаг агаарыг шинжих болон байгаль дэлхийтэй харьцах уламжлалт мэдлэг чадварын олон хэлбэрүүд, тахилгат газар, байгаль хамгаалах уламжлал, хорио цээрийн ёстой холбоотой өв гэх мэт;

5. Ардын гар урлал, уламжлалт арга ухааны өв

Монгол дархан, мужаан, модон эдлэлийн урлал, оёдол, хатгамал, эсгий ширмэл, арьс ширэн урлал, малын ашиг шимийг боловсруулах уламжлалт арга, ан агнуурын уламжлалт арга ухаан (технологи) гэх мэт.

б. Соёлын биет бус өв тээгч (цаашид Өв тээгч гэх) гэдэгт соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, сайдаас олгосон "Соёлын биет бус өв тээгч" батламж бүхий этгээдийг;

в. Соёлын биет бус өвийг өвлөн суралцагч (цаашид Өвлөн суралцагч гэх) гэдэгт Соёлын өвийн төвийн бүртгэлд орсон, өвлөн суралцаж байгаа "Соёлын биет бус өв тээгч"-ийн батламж аваагүй этгээдийг ойлгоно.

III. Соёлын биет бус өв, түүнийг тээгчийг тогтоох, бүртгэх

1. Монгол Улс дахь соёлын биет бус өвийн язгуур хэв шинж /цаашид Соёлын биет бус өв гэх/, соёлын биет бус өв тээгчийг тогтоох үйл ажиллагааг "Соёлын биет бус өв, түүнийг тээгчийг тогтоох Үндэсний зөвлөл" /цаашид Үндэсний зөвлөл гэх/ эрхэлнэ. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, сайд батална.

2. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харъяа-Соёлын өвийн төв /цаашид Соёлын өвийн төв гэх/ нь төв, орон нутгийн холбогдох соёл, урлагийн төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагатай хамтран "Орон нутаг дахь /аймаг, нийслэл, сум, баг, дүүрэг, хороо/ соёлын биет бус өв, түүнийг тээгчийн жагсаалт"-ын төслийг боловсруулна.

3. Соёлын өвийн төв нь Өв тээгчийг тогтоох /өв тээгчийн жагсаалтанд бүртгэх/ тухай шалгуур, ерөнхий зарыг жил бүрийн 11 дүгээр сард хэвлэл мэдээллийн хэрэгслээр байгууллага, иргэнд хүргэнэ.

4. Өв тээгчийн жагсаалтанд бүртгүүлэхийг хүсэгч (хувь хүн болон хамтлаг) нь өргөдлөө жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан Соёлын өвийн төвд гаргана. Өргөдөл нь олон нийтэд нээлттэй байна.

5. Соёлын өвийн төв нь өргөдлийг хянан үзээд шаардлагатай бол хүсэлт гаргагчийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, танилцуулга үйлдэнэ.

6. Соёлын өвийн төв нь "Орон нутаг дахь соёлын биет бус өв, түүнийг тээгчийн жагсаалт"-ын төсөл болон өв тээгчийн жагсаалтанд бүртгүүлэхээр хүсэлт гаргагчдын өргөдлийг үндэслэн "Монгол Улс дахь соёлын биет бус өвийн жагсаалт", "Монгол Улсын соёлын биет бус өв тээгч"-ийн жагсаалтын төслийг тус тус боловсруулж, холбогдох баримт бичиг, хэрэглэгдэхүүн, санал, дүгнэлтийн хамт жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан Үндэсний зөвлөлд хүргүүлнэ.

"Орон нутаг дахь соёлын биет бус өв, түүнийг тээгчийн жагсаалт"-ын төсөлд ороогүй өв болон өв тээгчийг "Монгол Улс дахь соёлын биет бус өвийн жагсаалт", "Монгол Улсын соёлын биет бус өв тээгчийн жагсаалт"-ын төсөлд тусгахгүй.

7. Үндэсний зөвлөл нь дээрх жагсаалтуудын төслийг хянан үзэж, жил бүрийн 8 дугаар сарын 10-ны өдрөөс өмнө хурлаараа хэлэлцэж, нэгдсэн санал, дүгнэлтээ Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, сайдад өргөн барина.

8. "Монгол Улс дахь соёлын биет бус өвийн жагсаалт", "Монгол улсын соёлын биет бус өв тээгчийн жагсаалт"-ын төсөл нь соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, сайдын баталснаар хүчин төгөлдөр болно.

9. Жагсаалт батлагдсан тухай мэдээллийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлан, Монголын соёл, урлагийн ажилтны өдөр /жил бүрийн 9 дүгээр сарын 2 дахь долоо хоногийн Ням гараг/- өөр Өв тээгчдэд батламж гардуулна.

10. Соёлын өвийн төв нь соёлын биет бус өв болон өв тээгчийн жагсаалтанд бүртгүүлэхээр гаргасан өргөдөлд хавсаргасан хийгээд Үндэсний зөвлөлд үзүүлж, сонсохоор хүргүүлсэн холбогдох хэрэглэгдэхүүн (баримтат кино, DVD, VCD, CD, аудио хуурцаг, ердийн болон дижитал гэрэл зураг, зураглал, тэмдэглээс, биет нотлох эд зүйлс гэх мэт), мөн Үндэсний зөвлөлийн шалгаруулалтын үеэр хийсэн бичлэг, тэмдэглэл болон бусад материалыг зохих журмын дагуу архивлан хадгална.

IV. Соёлын биет бус өв тээгчийн эрх

1. Өв тээгч (хувь хүн, хамтлаг) нь өөрийн эзэмшсэн соёлын биет бус өв, онцгой авъяас чадвараа хувийн өмч биш, харин ард түмний олон зуун жил эзэмшиж ирсэн соёлын өв гэж үзэхийн хамт түүнийг илэрхийлэх, сурталчлах, тоглолт, үзүүлбэрт оролцох, үзэсгэлэн гаргах, музей, клуб, хамтлаг байгуулах, сургалт явуулах зэрэг үйл ажиллагааг холбогдох эрх зүйн орчны хүрээнд эрхлэх, өв тээгчийн эрхээ шилжүүлэх;

2. Өв тээгч нь өөрийн үйл ажиллагааны талаархи санал, хүсэлтээ Соёлын өвийн төв, Соёл, урлагийн хороо, Үндэсний зөвлөл, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон холбогдох байгууллагад уламжлах;

3. Өв тээгч нь өөрийн эзэмшсэн соёлын биет бус өв, онцгой авъяас чадварын талаар судалгаа, сурталчилгааны бүтээл туурвих, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, тоглолт, үзүүлбэрээр нийтэд сурталчлах, энэ талаар нийгмийн бүлэг, байгууллага, хувь хүмүүстэй хамтарч ажиллах;

4. Өв тээгч нь өвлөн суралцагчийг өөрөө сонгон авах, авъяас чадвараа өвлүүлэх талаар өвлөн суралцагчид санал болгох.

V. Соёлын биет бус өв тээгчийн үүрэг

1. Өв тээгч (хувь хүн, хамтлаг) нь Соёлын өвийн төвтэй 2-3 жилийн хугацаатай гэрээ байгуулан ажиллах (гэрээ байгуулах журмыг Соёл, урлагийн хорооны дарга батална);

2. Өөрийн эзэмшсэн соёлын биет бус өв, авъяас чадвар, ялангуяа мартагдаж, устаж үгүй болоход хүрээд байгаа өвийг өвлөн суралцагчдаа язгуур байдлаар нь өвлүүлэх;

3. Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах талаар санаачлагатай ажиллаж, орон нутаг, улс, олон улсын чанартай соёлын арга хэмжээнд оролцож байх;

4. Уламжлан өвлөсөн онцгой авъяас чадвараа эрин цагийн хэрэгцээ, шаардлага, шинжлэх ухаан, технологийн ололтод нийцүүлэн хөгжүүлж байх;

5. Өвлөн суралцагчийг өв тээгчийн шалгаруулалтанд оруулах бэлтгэлийг хангуулах;

6. Үйл ажиллагааны тайлангаа жил бүрийн 11 дүгээр сард багтаан Соёлын өвийн төвд гарган өгч байх.

ҮІ. Өвлөн суралцагчийн эрх, үүрэг

1. Өвлөн суралцагч нь өв тээгч-багшаа сонгох, авъяас чадварыг нь өвлөн эзэмших хүсэлтээ түүнд хандан гаргах эрхтэй.

2. Өвлөн суралцагч нь сургалтын үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлтээ өв тээгч-багш болон Соёлын өвийн төвд гаргах, сургалтаас татгалзах эрхтэй.

3. Өвлөн суралцагч нь өөрийн эзэмшсэн авъяас чадварыг Соёлын өвийн төв, Үндэсний зөвлөлд үзүүлж, дүгнүүлэх үүрэгтэй.

4. Өвлөн суралцагч нь өөрийн сонгосон өвийн төрөл, зүйлээр идэвхи чармайлт гарган суралцаж, өв тээгч-багшийн авъяас чадварыг эзэмших, өв тээгчийн шалгаруулалтанд орох бэлтгэлийг хангах, шалгаруулалтад орох үүрэгтэй.

5. Өв тээгчийн шалгаруултад орохоор гаргасан өргөдөлд өөрчлөлт орвол тухайн үед Соёлын өвийн төвд мэдээлнэ.

-0-